

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2014 оны 12 сарын 31-ний өдөр

Д/д	Төлөвлөсөн ажил	Хэрэгжүүлсэн ажил	Хувь
1	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил тутам газрын хуралд мэдээллэх	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган танилцуулж ажиллав.	100%
2	Байгууллагын нууцыг хамгаалах журам, нууцад хамаарах баримт бичгийн жагсаалт гарган батлуулах, нууцыг хариуцах ажилтанг шинэчлэн томилох тушаал гарган батлуулах	Монгол Улсын Төрийн нууцын тухай хуулийн 12, 14, 17 дугаар зүйл, 19 дүгээр зүйлийн 19.4, Байгууллагын нууцын тухай хууль, Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-ын дагуу газрын даргын 2014 оны Б/18 дугаар тушаалаар "Төрийн болон байгууллагын нууцыг хамгаалах, нууц баримт бичигтэй ажиллах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Нууцад хамааруулах баримт бичгийн жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Нууцын ажилтан болон нууц баримт бичигтэй ажиллах албан тушаалтнаас авах баталгааны маяг"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталж, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын нууц баримт бичгийн бүртгэл, хадгалалт, ашиглалт, хариуцсан ажилтан /нууцын ажилтан/-аар тус газрын архив, бичиг хэргийн эрхлэгч /Ө.Ариунтунгалаг/-ийг томилж, дээрх журмыг мөрдөж ажиллаж байна.	100%
3	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн дагуу хугацаанд нь гаргаж эрх бүхий байгууллагад хүргүүлэх	Шинээр ажилд томилогдох 3 ажилтнаас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргуулан АТГ-аар хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул ажилд томилж 30 хоногийн дотор Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар, цаасаар хүлээн авч, Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ	100%

		<p>илэрхийлэх мэдэгдэл, тайлбарыг 19 ажилтнаар гаргуулан авч ажиллалаа. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зорилготой Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан шалгалтад хамрагдав. Шалгалтаар тус газрын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, мэдүүлгийн тайлан мэдээ, хөтлөлтөд зөрчил, дутагдал илрээгүй болно</p>	100%
4	<p>Ажилтнуудад давхар ажил эрхлэлттэй холбоотой жагсаалтыг танилцуулах, холбогдох журмын дагуу зөвшөөрөл олгох, хязгаарлалтыг хэрэгжүүлэх</p>	<p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйл Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт, 19 дүгээр зүйл Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмын талаар танилцуулж мэдээлж ажиллав.</p>	100%
5	<p>Бодлогын болон эрх зүйн баримт бичгийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа тусгах боломжийг бүрдүүлэх</p>	<p>"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, 2030 он хүртэлх чиг хандлагын баримт бичиг"-т тулгуурлан боловсруулсан "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг 2014 оны 9 дүгээр сарын 17-ны салбарын 500 гаруй төрийн болон бус байгууллага, аж ахуй нэгжийн төлөөлөлд танилцуулахаар зөвлөгөөн зохион байгуулж, зөвлөгөөний үеэр салбарынхны санал, шүүмжлэлийг хүлээн авах хэлэлцүүлэг зохион байгууллаа. Зөвлөгөөнд оролцогч 30 хүнээс бичгээр 52 асуулга, хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр 148 санал ирснийг үйл ажиллагаандаа тусган, асуулгын хариуг цахимаар хүргүүлэн ажиллаж байна.</p>	100%
6	<p>Ажилтнуудад Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах -мэдээллийн самбар -цахим хуудас -гарын авлага</p>	<p>Байгууллагын Хөдөлмөрийн Дотоод журам /10-т Газрын ил тод үйл ажиллагаа гэсэн 8 заалт/, Ёс зүйн дүрэм /2-т Ёс зүйн зарчим 1 заалт, 3-т Ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс 5 заалт, 4-т Албан хаагчийн дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ 6 заалт 28 дэд заалт/, Иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам /7 заалт/ -ын</p>	100%

		<p>авлигын эсрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой заалтуудыг онлайн хэлбэрээр, мэдээллийн самбарт байрлуулах зэргээр тогтмол сурталчилж мөрдөж ажиллаж байна. АТГ-аас 2014 онд хэвлэн гаргасан Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага эмхэтгэлийг ажилтнуудад өгч гарын үсэг зуруулан судлууллаа.</p>	
7	<p>Байгууллагаас гарч байгаа шийдвэр, мөрдөж ажиллах дүрэм журмын цахим хуулбарыг тухай бүр ажилтнуудад өгч байх, ажилтнууд өдөр тутам ашиглах фолгдер үүсгэх</p>	<p>Байгууллагаас гарч байгаа шийдвэр, мөрдөж ажиллах дүрэм журмын хуулбарыг цахимаар болон цаасаар хувилж тухай бүр ажилтнуудад өгч байх, ажилтнууд өдөр тутам ашиглах дотоод хавтас үүсгэн ашиглуулж байна.</p>	100%
8	<p>Удирдлагаас гарсан шийдвэр, тухайн жилийн төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг ажлын 3 хоногийн дотор цахим хуудаст байршуулж байх</p>	<p>www.tourism.uib.gov.mn цахим хуудсыг шинэчлэн мэдээллийн ил тод байдал, шилэн дэнс, удирдлагаас гарсан тушаал шийдвэр цэс үүсгэн тухайн жилийн төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, тус газраас олгосон зөвшөөрлийн эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг заасан нийт 199 зочид буудал, 97 дэн буудал, 5 амралтын газарт зөвшөөрөл олгосон тушаал шийдвэр, газрын бүтцийн хөтөлбөр, дүрэм журам мэдээллийн тогтмол шинэчлэн цаг тухай бүр цахим хуудаст байршуулж байна.</p>	100%
9	<p>Иргэд, байгууллагад олгож буй зөвшөөрлийн жагсаалт, олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, олгох журмыг хялбаршуулах, шат дамжлагыг цөөрүүлэх</p>	<p>Хүнд суртал, чирэгдэлгүй ажиллах, шат дамжлагыг цөөрүүлэх, иргэд нэг дороос төрийн үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор аялал жуулчлалын байр сууцны зөвшөөрөл авах иргэдэд үйлчилдэг албан хаагчдыг нэг дор /үйлчилгээний чанар, стандарт хариуцсан ахлах мэргэжилтэн, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, сургалт хариуцсан мэргэжилтэн, бичиг хэргийн эрхлэгч нар/, гадаад дотоодын жуулчид, тур оператор, трэвел агентуудад үйлчилдэг ажилтнуудыг нэг дор /Мэдээлэл сурталчилгааны төвийн менежер, Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн, Маркетинг сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, Статистик, судалгаа хариуцсан мэргэжилтэн/ суулгаж байна. Энэ арга хэмжээг авснаар өмнө нь 1-р давхрын мэдээллийн төвөөс мэдээлэл авсан иргэн 6-р давхарт байрлах ажилтанд</p>	100%

		материал өгөх зэргээр чирэгдэл, хүлээгдэл гардаг байсан асуудал шийдвэрлэгдсэн.	
10	Тус газраас олгосон зөвшөөрлийн эзэмшигчийн нэр, хаяг, эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дууссан хугацааг цахим хуудсанд байршуулж байх	Тус газраас олгосон зөвшөөрлийн эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг заасан нийт 199 зочид буудал, 97 дэн буудал, 5 амралтын газарт зөвшөөрөл олгосон тушаал шийдвэрийг цахим хуудсанд байршуулсан.	100%
11	Иргэдтэй харилцах асуудал хариуцсан албан хаагчийн нэр, хаяг, албан тушаал, утасны дугаар болон хүний нөөцийн бодлого шийдвэр, түүний хэрэгжилт, сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг ил тод нээлттэй байлгах	Нийслэлийн Мэдээлэл, технологийн газарт албан тоот хүргүүлэн тус газрын www.tourism.ub.gov.mn хуудсанд нийслэлийн Аялал жуулчлалын газрын ажилтнуудын албан тушаал, холбоо барих утасны дугаар, тус газраас үзүүлдэг төрийн үйлчилгээтэй холбоотой дүрэм, журам, бүрдүүлэх материалын жагсаалт хэсгийг шинээр оруулж мэдээлэл авах нэмэлт функцийг суулгасан.	100%
12	Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	Бараа, үйлчилгээг харьцуулалтын аргаар авах судалгаа хийж Нийслэлийн Өмчийн харилцааны газрын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөгдсөний дагуу шалгарсан байгууллагатай гэрээ байгуулж, харьцуулалт хийж гэрээ байгуулсан ажилтнуудаар "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг хуулийн дагуу бөглүүлэн авч байна. Одоогийн байдлаар тус газартай холбоотой худалдан авах ажиллагаа болон тендерын ажил зохион байгуулаагаадгүй болно	100%
13	Ёс зүй, авлигын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх /утас, цахим хуудас, цахим шуудан, санал хүсэлтийн хайрцаг/	Албан хаагчдын идэвх санаачилга, бүтээлч, ажил хэрэгч байдлыг дээшлүүлж чадваржуулах, тэдний харилцааны соёл, төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэн сахиулах, хариуцлагын тогтолцоог төлөвшүүлэх зорилгоор байгууллагын үйл ажиллагаа, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар иргэдийн санал, хүсэлт, шүүмжлэл хүлээн авах санал хүсэлтийн дэвтэр, цахим хуудсыг тогтмол ажиллуулж байна. 2014 оны байдлаар тус газарт авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн үйлчилгээтэй холбоотой санал	100%

	гомдол иргэдээс ирээгүй байна.	
	Хэрэгжилтийн дүн	100%

ХЯНАЖ ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
 ГАЗРЫН ДАРГА Э.БАТТУЛГА



Огноо: 2014.12.31.

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
 ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН



Э.МӨНХЗУЛ
 Огноо: 2014.12.31.